



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 240

Улаанбаатар хот

“Талын зам” ХК-ийн үнэт цаасыг
үнэт цаасны бүртгэлд бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7, Компанийн тухай хуулийн 11.1, 42 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 170 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 2012 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 230 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Талын зам” ХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 4,012,634 /дөрвөн сая арван хоёр мянга зургаан зуун гучин дөрөв/ ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Саруул/, хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Талын зам” ХК /Ш.Мөнхдар/-д үүрэг болгосугай:


1/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

2/ Хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ийг мөрдөж ажиллах;

3/ Энэхүү тогтоолын 1, 2-т заасан өөрчлөлтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, өөрчлөлтийг тэмдэглүүлэн Хороонд ажлын 10 хоногийн дотор ирүүлэх;

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН